



“ИНВЕСКОР ББСБ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН  
ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

2023 оны 4 дүгээр сарын 14-ний өдөр

№ A/01

Улаанбаатар хот

*Компанийн 2022 оны үйл ажиллагааны болон санхүүгийн  
тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн  
дүгнэлтийг хэлэлцэн батлах тухай*

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9 дэх заалт, “Инвескор ББСБ” ХК (цаашид “Компани” гэх)-ийн Дүрмийн 8 дугаар зүйлийн 8.5.10 дах заалт болон хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын A/01 дугаар шийдвэрийг тус тус үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Компанийн 2022 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг баталсугай.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ДАРГА





“ИНВЕСКОР ББСБ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН  
ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

2023 оны 4 дүгээр сарын 14-ний өдөр

№ A/02

Улаанбаатар хот

*Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны төсвийг батлах тухай*

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.13 дах заалт, “Инвескор ББСБ” ХК (цаашид “**Компани**” гэх)-ийн Дүрмийн 8 дугаар зүйлийн 8.5.14 дэх заалт болон хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын 23/02 дугаар шийдвэрийг тус тус үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны үйл ажиллагааны төсвийг энэхүү тогтоолын Хавсралтаар баталсугай.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ДАРГА



"ИНВЕСКОР ББСБ" ХК

"Инвекор ББСБ" ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн  
ээлжит хурлын 2023 оны 04 дүгээр сарын 11-ний  
өдрийн 4/02 дугаар тогтоолын Хавсралт



### ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН 2023 ОНЫ ТӨСӨВ

№	Төсөв	Тоо ширхэг	Нэгж /төгрөг/	Нийт дүн* /төгрөг/	Тайлбар
1	ТУЗ-ийн гишүүдийн цалин урамшуулал		138,000,000		Гишүүнд цалин олгоно
2	ТУЗ-ийн нарийн бичгийн даргын цалин урамшуулал	1	550,000	6,600,000	
3	ТУЗ-ийн хурлын зардал	4	250,000	1,000,000	Улиралд 1 удаа
4	Томилолтын зардал	2	5,000,000	10,000,000	Хагас жилд 1 удаа
5	Бусад		300,000 (1 сард)	3,600,000	
Нийт зардлын дүн				159,200,000	

\*2024 оны 04-р сарыг дуустал 12 сарын нэгтгэсэн дүнгээр



“ИНВЕСКОР ББСБ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН  
ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

2023 оны 4 дүгээр сарын 14-ний өдөр

№ A/03

Улаанбаатар хот


*Компанийн хувьцаа хуваах шийдвэрт өөрчлөлт оруулах тухай*

Компанийн тухай хуулийн 51 дүгээр зүйл, 62 дугаар зүйлийн 62.1.1, 62.1.6 дах заалт, Компанийн дүрмийн 8 дугаар зүйлийн 8.5.1, 8.5.6 дах заалт болон хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын A/03 дугаар шийдвэрийг тус тус үндэслэн **ТОГТООХ** нь:

1. Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын 2022 оны 09 дүгээр сарын 07-ны өдрийн №A/05 тоот “Компанийн хувьцаа хуваах төслийг батлах тухай” тогтоолыг дараах байдлаар өөрчилсүгэй. Үүнд:
  - 1.1. Компанийн нэг бүр нь 227 төгрөгийн нэрлэсэн үнэтэй, нийт 82,000,000 ширхэг зарласан энгийн хувьцааны нэг хувьцаа бүрийг 10 хувааж, нэг бүр нь 22.7 төгрөгийн нэрлэсэн үнэтэй нийт 820,000,000 ширхэг зарласан энгийн хувьцаа болгон хуваасугай.
  - 1.2. Компанийн нэг бүр нь 227 төгрөгийн нэрлэсэн үнэтэй, нийт 75,744,281 ширхэг гаргасан энгийн хувьцааны нэг хувьцаа бүрийг 10 хувааж, нэг бүр нь 22.7 төгрөгийн нэрлэсэн үнэтэй нийт 757,442,810 ширхэг гаргасан энгийн хувьцаа болгон хуваасугай.
  - 1.3. Компанийн хувьцааг хуваах зорилго, үндэслэл, хувьцаа хуваах ажлыг гүйцэтгэх журмыг тусгасан “Хувьцаа хуваах төсөл”-ийг энэхүү тогтоолын нэгдүгээр хавсралтаар баталсугай.
  - 1.4. Энэхүү тогтоолоор батлагдсан “Хувьцаа хуваах төсөл”-ийг хэрэгжүүлэх, Үнэт цаасны бүртгэлийн журмын дагуу “Монголын хөрөнгийн бирж” ХК-д хувьцаа хуваах хүсэлт гаргах, Санхүүгийн зохицуулах хороонд бүртгүүлэх, зөвшөөрөл авах болон бусад эрх бүхий байгууллагад мэдээлэл хүргүүлэх, бүртгүүлэх, зөвшөөрөл авахыг Гүйцэтгэх захирал (Д. Баясгалан)-д даалгасугай.
  - 1.5. Хувьцаа хуваах шийдвэрийг холбогдох эрх бүхий байгууллагад бүртгүүлж, зөвшөөрөл авсны дараа “Хувьцаа хуваах төсөл”-ийн хамтаар баталсан Компанийн дүрмийн нэмэлт өөрчлөлтийг Улсын бүртгэлийн ерөнхий газрын Хуулийн этгээдийн бүртгэлийн газарт бүртгүүлэхийг Гүйцэтгэх захирал (Д. Баясгалан)-д даалгасугай.

2. Энэхүү тогтоолоор баталсан “Хувьцаа хуваах төсөл”-ийг 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн дотор хэрэгжүүлэхийг Гүйцэтгэх захирал /Д. Баясгалан/-д даалгасугай.
3. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, хэрэгжилтийг хангуулахыг Төлөөлөн удирдах зөвлөлд үүрэг болгосугай.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИЙН ХУУЛЫН ДАРГА







“Инвекор ББСБ” ХК-ийн 2023 оны 04 дүгээр сарын 14-ний өдрийн  
Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын 103 тоот тогтоолын хэсэг

## “ИНВЕСКОР ББСБ” ХК-ИЙН ХУВЬЦАА ХУВААХ ТӨСӨЛ

### НЭГ.ЗОРИЛГО

Уг төслийн зорилго нь Компанийн энгийн хувьцааг хуваан хувьцааны тоо ширхгийг нэмэгдүүлж, нэгж хувьцааны зах зээлийн үнийг бууруулснаар хувьцааны хөрвөх чадвар болон арилжааны идэвхийг нэмэгдүүлэхэд оршино.

### ХОЁР. ҮНДЭСЛЭЛ

Компанийн тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.5-д “Компанийн хувьцааг нэгтгэх буюу хуваах тухай асуудлыг хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцож байгаа хувьцаа эзэмшигчдийн дийлэнх олонхийн саналаар шийдвэрлэнэ” гэж, 62 дугаар зүйлийн 62.1.6-д хувьцааг хуваах буюу нэгтгэх шийдвэрийг Хувьцаа эзэмшигчдийн бүрэн эрхэд хамааруулна гэж тус тус заасан. Иймд “Инвекор ББСБ” ХК-ийн нэг энгийн хувьцааг 100 ширхэг энгийн хувьцаанд хуваах тухай хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын шийдвэрт өөрчлөлт оруулж, нэг энгийн хувьцааг 10 ширхэг энгийн хувьцаанд хуваах шийдвэр гаргах эрхийг хувьцаа эзэмшигчдийн хурал хэрэгжүүлнэ. Компанийн хувьцааг хуваах шийдвэр гаргаснаар дараах ач холбогдолтой гэж үзэж байна.

Компаний хувьцааг хуваахын давуу тал:

- Хувьцааны арилжааны идэвх болон хөрвөх чадварыг нэмэгдүүлнэ.
- Олон тооны жижиг хөрөнгө оруулагчдыг арилжаанд идэвхтэй оролцуулна.
- Компанийн хувьцааг хямд гэсэн сэтгэлзүйн нөлөөлөл үүсгэнэ.
- Компанийн хувьцааны ханшийн өсөлтийг олон нийтэд таниулна.

Компанийн зүгээс зах зээлийн нөхцөл байдал болон үйл ажиллагааны цаашдын төлөвлөгөөтэй уялдуулан компанийн нэг энгийн хувьцааг 100 хуваах саналыг 10 болгож өөрчлөх саналыг гаргаж байна. Ийнхүү өөрчлөлт оруулах саналыг дараах нөхцөлийг харгалзан гаргасан болно. Үүнд:

- 2022 оны 2 сараас эхлэн төгрөгийн ханш ам. долларын эсрэг 23 хувиар суларсан мөн цаашид ханшийн тогтворгүй байдал үргэлжлэх хандлагатай байгаа нь нэгж хувьцааг 100 хуваах анхны төсөөлөлд өөрчлөлт оруулах шаардлага үүсгэсэн. Компанийн нэгж энгийн хувьцааг 100 хувааснаар зах зээлийн үнэ 50 төгрөг гаруй буюу ам. доллараар 2 цент болж байгаа нь олон улсын зах зээл дээрх компанийн үнэлэмж, хөрөнгө оруулагчдад харагдах байдалд сөрөг нөлөө үзүүлэхээр байна.

- Олон улсын сайн туршлагаас үзэхэд компанийн хувьцааг нэг удаа 100 хуваах бус хэсэгчлэн буюу үе шаттайгаар хуваах нь компанийн хувьцааны арилжааны идэвх болон хөрвөх чадварт урт хугацааны эерэг нөлөө үзүүлнэ.

## **ГУРАВ. ХУВЬЦАА ХУВААХ ҮЙЛ АЖИЛЛАГААГ ГҮЙЦЭТГЭХ ЖУРАМ**

3.1. Компанийн хувьцаа хуваах тухай асуудлыг Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцүүлэн Компанийн тухай хуулийн 51, 63 дугаар зүйлд заасны дагуу шийдвэрлэнэ.

3.2. Хувьцаа эзэмшигчдийн хурлыг зарлан хуралдуулах тухай шийдвэрийг 2023 оны 03 дугаар сарын 02-ны өдрийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаар батална.

3.3. ТУЗ-ийн хурлын шийдвэр гарсны дараа Санхүүгийн зохицуулах хорооны 2018 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн 377 дугаар тогтоолын хавсралтаар баталсан Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын тухай мэдэгдлийг Санхүүгийн зохицуулах хороо болон “Монголын хөрөнгийн бирж” ХК-д ТУЗ-ийн шийдвэрийн хуулбар болон хурлын тухай олон нийтэд хүргэх зарын загварын хамт хүргүүлнэ. Түүнчлэн уг журмын дагуу хувьцаа эзэмшигчдийн хурлын зарыг олон нийтэд хүргэнэ.

3.4. Энэхүү төслийг Санхүүгийн зохицуулах хорооны 2018 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн 377 дугаар тогтоолын хавсралтаар баталсан Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журамд заасны дагуу бүртгэх өдрөөр тасалбар болгон гаргасан тархалтын мэдээнд үндэслэн хувьцаа эзэмшигчдэд үйлчилдэг Үнэт цаасны компаниудад хүргэх, “Монголын хөрөнгийн бирж” ХК-ийн цахим хуудсанд байршуулах, энэхүү төсөл болон хурлын материалыг олон нийтийн хэвлэлд нийтлэх замаар хувьцаа эзэмшигчдэд танилцуулна.

3.5. Энэхүү төслийг хэлэлцэх хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2023 оны 04 дүгээр сарын 14-ний өдөр хуралдуулна.

3.6. Компанийн тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.5 болон 62 дугаар зүйлийн 62.1.6-д заасны дагуу хувьцааг хуваах тухай шийдвэрийг хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцож байгаа саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн дийлэнх олонх зөвшөөрсөн тохиолдолд хувьцааг хуваах тухай шийдвэр гарна.

3.7. Хувьцааг хувааснаар компанийн дүрэмд заасан хувьцааны нэрлэсэн үнэ, тоо ширхэг өөрчлөгдөх тул компанийн дүрэмд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийг энэхүү Хувьцаа хуваах төслийн хамт хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд танилцуулж, батлах асуудлыг шийдвэрлэнэ.

3.8. Хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэр гарсны дараа хурлын материалыг Санхүүгийн зохицуулах хороо болон “Монголын хөрөнгийн бирж” ХК-д хүргүүлнэ.

3.9. Хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэр гарсны дараа хурлын тогтоолд заасан хэрэгжүүлэх хугацааны дотор “Монголын хөрөнгийн бирж” ХК-ийн Үнэт цаасны бүртгэлийн журмын 19 дүгээр зүйлд заасан материалыг бүрдүүлэн хувьцааг хуваах асуудлыг шийдвэрлүүлэх хүсэлтээ “Монголын хөрөнгийн бирж” ХК-д хүргүүлнэ.

3.10. “Монголын хөрөнгийн бирж” ХК-иас хувьцааг хуваах замаар хувьцааны бүртгэлд өөрчлөлт оруулах шийдвэр гарснаас хойш ажлын 3 хоногийн дотор Санхүүгийн зохицуулах хороо болон “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК-д мэдээлэл хүргүүлнэ.

3.11. “Монголын хөрөнгийн бирж” ХК-ийн шийдвэр гарснаас хойш Санхүүгийн зохицуулах хорооны Үнэт цаасны бүртгэлийн журамд заасан материалыг бүрдүүлэн Санхүүгийн зохицуулах хороонд хүргүүлж, хувьцааны бүртгэлд орсон өөрчлөлтийг бүртгүүлнэ.

3.12. Санхүүгийн зохицуулах хорооны үнэт цаасны бүртгэлд өөрчлөлт оруулах тухай шийдвэр гарсны дараа үнэт цаасны хадгаламжийн бүртгэлд өөрчлөлт оруулна.

3.13. Холбогдох бүх өөрчлөлт хийгдсэний дараа Улсын бүртгэлийн ерөнхий газрын Хуулийн этгээдийн бүртгэлийн газарт дүрмийн нэмэлт, өөрчлөлтийг бүртгүүлснээр хувьцааг хуваах үйл ажиллагаа бүрэн хэрэгжсэн гэж үзнэ.

3.14. Хувьцаа хуваах үйл ажиллагаа хэрэгжиж буйтай холбогдуулан эрх бүхий байгууллагын шийдвэрээр хувьцааны арилжааг түр зогсоож болно.

### **ДӨРӨВ. ХУВЬЦАА ХУВААХТАЙ ХОЛБООТОЙ ҮҮССЭН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭРХИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ**

Компани хувьцаа хуваах үйл ажиллагааг хэрэгжүүлэхтэй холбогдуулан хувьцаа эзэмшигчдээс хэрэгжүүлэх аливаа үүрэг, эрх байхгүй болно.

### **ТАВ. ХУВЬЦАА ХУВААХ ТООЦООЛОЛ**

2023 оны 03 сарын 01-ний өдрөөр компанийн энгийн хувьцааны зах зээлийн хаалтын ханш 5400 төгрөг, зах зээлийн үнэлгээ 409 тэрбум төгрөг байна. Компанийн нэг бүр нь 227 төгрөгийн нэрлэсэн үнэтэй энгийн хувьцаа нэг бүрийг 22.7 төгрөгийн нэрлэсэн үнэтэй 10 ширхэг энгийн хувьцаа болгон хөрвүүлэх замаар хуваана.

Ингэснээр компанийн зарласан бөгөөд гаргасан энгийн хувьцааны тоо ширхэг, нэрлэсэн үнэ, зах зээлийн ханш доорх байдлаар өөрчлөгдөнө.



<b>Үзүүлэлт</b>	<b>Одоо байгаа</b>	<b>Хуваасны дараа</b>
Хуваах харьцаа	1:1	10:1
Нийт зарласан энгийн хувьцаа	82,000,000 ширхэг	820,000,000 ширхэг
Нийт гаргасан энгийн хувьцаа	75,744,281 ширхэг	757,442,810 ширхэг
Зах зээлийн ханш (2023.03.01)	5400 төгрөг	540 төгрөг
Энгийн хувьцааны нэрлэсэн үнэ	227 төгрөг	22.7 төгрөг



“ИНВЕСКОР ББСБ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН  
ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

2023 оны 4 дүгээр сарын 14-ний өдөр

№ А/04

Улаанбаатар хот

*Хаалттай хүрээнд давуу эрхийн хувьцаа гаргах,  
компанийн дүрмийн шинэчилсэн найруулгыг батлах тухай*

Компанийн тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.3 дах заалт, 35 дугаар зүйлийн 35.9 дэх заалт, “Инвескор ББСБ” ХК (цаашид “Компани” гэх)-ийн Дүрмийн 5 дугаар зүйлийн 5.5, 6 дугаар зүйлийн 6.13, 7 дугаар зүйлийн 7.1 дэх заалт болон хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын М/04 дугаар шийдвэрийг тус тус үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийг нэмэгдүүлэх зорилгоор нэг бүр нь 5,000 (таван мянган) төгрөгийн нэрлэсэн үнэтэй 6,000,000 (зургаан сая) ширхэг, нийт 30,000,000,000 (гучин тэрбум) төгрөгийн үнэтэй давуу эрхийн хувьцааг зарласугай.
2. Компанийн зарласан давуу эрхийн хувьцааг дараах нөхцөлөөр гаргасугай. Үүнд:

Гаргах хэлбэр	Хаалттай хүрээнд
Зорилго	Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийг нэмэгдүүлэх
Нийт гаргах давуу эрхийн хувьцааны тоо ширхэг	6,000,000 (зургаан сая)
Давуу эрхийн хувьцааны нэрлэсэн үнэ	5,000 (таван мянган) төгрөг
Татан төвлөрүүлэх хөрөнгийн дүн	30,000,000,000 (гучин тэрбум) төгрөг
Татан төвлөрүүлсэн хөрөнгийг зарцуулах зориулалт	Компанийн үндсэн үйл ажиллагааг санхүүжүүлэх
Давуу эрхийн хувьцааг анхдагч зах зээлд санал болгох үнэ	Нэрлэсэн үнээр буюу нэг бүр нь 5,000 (таван мянган) төгрөг
Давуу эрхийн хувьцааны саналын эрх	Давуу эрхийн нэг хувьцаа нэг саналын эрхтэй

<b>Давуу эрхийн хувьцааны нөхцөл</b>	Компани эргүүлэн худалдан авах нөхцөлтэй
<b>Хувьцаа эзэмшигч давуу эрхийн хувьцааг компанид эргүүлэн худалдах эрхээ хэрэгжүүлэх хугацаа</b>	Давуу эрхийн хувьцааны анхдагч зах зээлийн арилжаа амжилттай болсон өдрөөс хойш 5 жилийн дараа
<b>Компани давуу эрхийн хувьцааг эргүүлэн худалдан авах үнэ</b>	Нэрлэсэн үнээр буюу нэг бүр нь 5,000 (таван мянган) төгрөг
<b>Ногдол ашиг олгох валют</b>	Төгрөг
<b>Ногдол ашгийн хувь хэмжээ /жилээр/</b>	Монголбанкны бодлогын хүү + 5% (эзэмшиж буй давуу эрхийн хувьцааны нэрлэсэн үнийн дүнгээс тооцно)
<b>Ногдол ашгийн хувь хэмжээг тооцох суурь</b>	Тухайн жилийн 12 дугаар сарын 31-ний өдрийн Монголбанкны бодлогын хүүг үндэслэнэ.
<b>Ногдол ашиг олгох давтамж</b>	Жил бүр (дараа жилийн 4 сарын 30-ны өдрөөс өмнө олгоно)
<b>Татан буулгалтын үнэ</b>	Давуу эрхийн хувьцааны нэрлэсэн үнээр

3. Давуу эрхийн хувьцаа шинээр гаргасантай холбогдуулан Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийг нэмэгдүүлж, нийт хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг 47,193,951,800 (дөчин долоон тэрбум нэг зуун ерэн гурван сая есөн зуун тавин нэгэн мянга найман зуун) төгрөгөөр тогтоосугай.
4. Давуу эрхийн хувьцааг эргүүлэн худалдан авах нөхцөлийг хөрөнгө оруулагчтай байгуулах Хувьцаа захиалгын гэрээнд тусгаж, уг гэрээний загварыг батлахыг Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлд үүрэг болгосугай.
5. Давуу эрхийн хувьцааг хаалттай хүрээнд гаргахтай холбогдуулан давуу эрхийн хувьцаа эзэмшигчтэй Хувьцаа захиалгын гэрээг Компанийн нэрийн өмнөөс байгуулах эрхийг Гүйцэтгэх захирал /Д. Баясгалан/-д олгосугай.
6. Энэхүү тогтоолд тусгасан нөхцөл болон давуу эрхийн хувьцааг компанид эргүүлэн худалдах эрхийг хэрэгжүүлэх нөхцөл, давуу эрхийн хувьцаа эзэмшигч хувьцаа эзэмшигчдийн хуралд саналын эрхтэй оролцох нөхцөл, компани татан буугдах үед давуу эрхийн хувьцаа эзэмшигчид төлбөр төлөх журам, дэс дарааллыг тусгасан Компанийн дүрмийн шинэчилсэн найруулгыг энэхүү тогтоолын нэгдүгээр хавсралтаар баталсугай.
7. Давуу эрхийн хувьцаа гаргахтай холбогдуулан Компанийн үнэт цаасны бүртгэлд өөрчлөлт оруулах талаар Санхүүгийн зохицуулах хороо болон Монголын хөрөнгийн

бирж ХК-д шаардлагатай материалыг хүргүүлэх, зохих бүртгэлийг хийлгэх, бүртгэл хийлгэхтэй холбоотой шаардлагатай бусад арга хэмжээг авч ажиллахыг Гүйцэтгэх захирал /Д. Баясгалан/-д даалгасугай.

8. Давуу эрхийн хувьцаа гаргаж, анхдагч зах зээлийн арилжаа амжилттай биелснээр тогтоолын нэгдүгээр хавсралтаар баталсан Компанийн дүрмийн шинэчилсэн найруулгыг холбогдох улсын бүртгэлийн байгууллагад бүртгүүлэхийг Гүйцэтгэх захирал /Д. Баясгалан/-д үүрэг болгосугай.
9. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, хэрэгжилтийг хангуулахыг Төлөөлөн удирдах зөвлөлд үүрэг болгосугай.

ХУВЬЦАА ЭЗЭМНИГЧИЛЭЙН ХУРЛЫН ДАРГА





“ИНВЕСКОР ББСБ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН  
ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

2023 оны 4 дүгээр сарын 14-ний өдөр

№ A/05

Улаанбаатар хот

*Компанийн дүрмийн нэмэлт, өөрчлөлтийг батлах тухай*

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.1 дэх заалт, “Инвескор ББСБ” ХК (цаашид “Компани” гэх)-ийн Дүрмийн 8 дугаар зүйлийн 8.5.1 дэх заалт болон хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын 25/05 дугаар шийдвэрийг тус тус үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Компанийн үйл ажиллагааны чиглэл болон эрх бүхий албан тушаалтанд өөрчлөлт орсонтой холбогдуулан дүрмийн нэмэлт, өөрчлөлтийг энэхүү тогтоолын нэгдүгээр хавсралтаар баталсугай.
2. Компанийн дүрмийн нэмэлт, өөрчлөлтийг холбогдох хууль тогтоомжид заасан хугацаанд Санхүүгийн зохицуулах хороо болон Улсын бүртгэлийн ерөнхий газрын Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн газарт хүргүүлж, зохих бүртгэлийг хийлгэх ажлыг удирдан зохион байгуулах, шаардлагатай бусад арга хэмжээг авч ажиллахыг Гүйцэтгэх захирал /Д. Баясгалан/-д даалгасугай.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ДАРГА

